

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар: 10

Улаанбаатар хот

**Б.Ангарыг ажилд шилжүүлэн  
томилох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 81 дүгээр зүйлийн 81.4.2, 81.6.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 49 дүгээр зүйл, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг заасныг тус тус үндэслэн ТӨГТООХ нь:

1. Компанийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонд холбогдуулан дотоод хяналтын ажилтан Батцэнгэлийн Ангарыг 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дотоод аудитын ажилтны ажил, албан тушаалд шилжүүлэн томилсугай.

2. Хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод (журам) хэм хэмжээнд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлөн Б.Ангартай шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (З.Энхболд)-д, дотоод аудитын ажилтанд олгох цалин, урамшууллын санал боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Цалин, урамшууллын хороо (Ц.Түмэнхишиг)-нд, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Жавхлангад тус тус үүрэг болгосугай.

3. Б.Ангарын цалинг хөдөлмөрийн гэрээгээр тохирсон хэмжээгээр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Ч.Соронзонболд)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолыг Б.Ангарт танилцуулахыг Захиргаа, удирдлагын газрын дарга (Э.Ванчинхүү)-д даалгасугай.

ДАРГА

3.ЭНХБОЛД

